

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/96/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: huanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Аудитор: С.Нурлан Утас: 94209011 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	Error! Bookmark not defined.
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Залруулсан алдаа.....	14
4.2 Төлбөрийн акт.....	15
Байхгүй	Error! Bookmark not defined.
4.3 Албан шаардлага	15
4.4 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

УЛААНХУС СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
2 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Х.ӨМИРГҮЛ ТАНАА

᠒᠐᠒᠒ - ᠐᠒ - ᠒᠕ № 13᠑
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Хүнсний материалын данснаас 20548.7 мянган төгрөгийн материалыг урьд жилүүдэд хоолны зардлын төсвөөс авч хүнсний материал дансанд бүртгэж ирсэн гэж 17416.6 мянган төгрөгийг үндсэн хөрөнгөнд шилжүүлэн, 3132.1 мянган төгрөгийн материалыг данснаас хасжээ. Ингэхдээ дээрх тооцоо үнэн зөв эсэхийг хянаж баталгаажуулаагүй, баримтжуулалт нь хангалтгүй байна. Энэ нь урьд жилүүдэд хөрөнгө, бараа материалын бүртгэл тооцоо, тооллогыг зохих журмаар хийгээгүй, өмнөх оны аудитаар хүнсний материалын бүртгэл, тооллоготой холбоотой зөрчлийг санаатай нуун дарагдуулсан байх магадлалтай байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.3, 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалт болон иж бүрэн байх, толилуулга, оршин байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>159144337.89</u>	<u>115196226.99</u>
33	АВЛАГА	11925238.00	0.00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	11925238.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	147219099.89	115196226.99
351	Түүхий эд материал	0.00	145455.00
35130	Эм боох материал	0.00	145455.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	27053879.39	0.00
354	Хангамжийн материал	120165220.50	115050771.99
35410	Бичиг хэргийн материал	1500750.00	1252350.00
35420	Аж ахуйн материал	48661428.00	79753257.39
35440	Түлш, шатах тослох материал	15865425.50	7528445.50
35460	Хүнсний материал	53490617.00	25869719.10
35470	Бусад хангамжийн материал	647000.00	647000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2621044124.62</u>	<u>3887888294.94</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2621044124.62	3887888294.94
392	Биет хөрөнгө	2615844157.90	3882788311.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	2367329805.26	3970330805.26
39202	Хуримтлагдсан элэгдэл	-101467039.24	-197069041.74
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	99841498.00	111464098.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-74926268.38	-85454083.92
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	79241542.66	93860542.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	-53723460.40	-64680428.76
39216	Дуусаагүй барилга, байгууламж	250000000.00	0.00
39217	Ном	49548080.00	54336420.00
393	Биет бус хөрөнгө	5199966.72	5099983.44
39301	Програм хангамж	849950.00	849950.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-649983.28	-749966.56
39303	Бусад биет бус хөрөнгө	5000000.00	5000000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2780188462.51</u>	<u>4003084521.93</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>20355340.00</u>	<u>11214500.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20355340.00	11214500.00
413	Өглөг	20355340.00	11214500.00
4136	Бусад өглөг	20355340.00	11214500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	20355340.00	11214500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2759833122.51</u>	<u>3991870021.93</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2759833122.51	3991870021.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	152806215.00	152806215.00
51101	Өмч: - төрийн	152806215.00	152806215.00

512	Хуримтлагдсан үр дүн	1481726565.94	2735709276.47
51210	Өмнөх үеийн үр дүн	1246669228.42	1503672377.05
51220	Тайлант үеийн үр дүн	235057337.52	1232036899.42
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1125300341.57	1103354530.46
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2780188462.51</u>	<u>4003084521.93</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			Төгрөгөөр
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,290,882,355.00	2,350,599,662.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,436,157.00	1,723,640.00
120	Нийтлэг татварын бус орлого	20,436,157.00	1,723,640.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	20,436,157.00	1,723,640.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	20,436,157.00	1,723,640.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,270,446,198.00	2,348,876,022.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,224,547,176.00	2,296,103,140.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	255,543,176.00	1,356,487,640.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	969,004,000.00	939,615,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,000,000.00	8,662,933.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	8,662,933.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,013,600.00	38,784,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,013,600.00	38,784,000.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	4,000,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,885,422.00	5,325,949.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	10,885,422.00	5,325,949.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,055,614,152.47	1,118,562,762.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,055,614,152.47	1,118,562,762.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,008,162,760.47	1,084,074,278.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	745,170,460.00	734,506,163.00
210101	Үндсэн цалин	643,811,048.00	656,305,563.00
210104	Урамшуулал	68,893,200.00	41,897,600.00

210105	Гэрээт ажлын хөлс	32,466,212.00	36,303,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,910,500.00	97,232,100.00
210201	Тэтгэврийн даатгал	72,955,900.00	68,422,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,488,700.00	7,202,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,990,900.00	5,762,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,497,700.00	1,440,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,977,300.00	14,404,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,219,630.00	42,385,550.00
210301	Гэрэл, цахилгаан	1,899,330.00	3,074,000.00
210302	Түлш, халаалт	39,320,300.00	39,311,550.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,964,332.00	9,004,557.00
210401	Бичиг хэрэг	512,650.00	1,823,883.00
210402	Тээвэр, шатахуун	944,800.00	1,475,724.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,008,000.00	1,227,800.00
210404	Ном, хэвлэл	103,900.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,394,982.00	4,477,150.00
2105	Норматив зардал	42,518,903.00	71,132,242.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	258,600.00	2,694,285.00
210502	Хоол, хүнс	41,420,303.00	66,378,957.90
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	840,000.00	2,059,000.00
2107	Томилолт, зочны зардал	540,000.00	285,600.00
210702	Дотоод албан томилолт	540,000.00	285,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	702,400.00	1,677,946.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	102,400.00	1,177,946.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,136,535.47	127,850,119.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		8,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,403,000.00	2,663,350.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61,733,535.47	117,186,769.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,451,392.00	34,488,484.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,416,322.00	33,428,409.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	10,885,422.00	5,325,949.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,530,900.00	28,102,460.00

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,035,070.00	1,060,075.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,035,070.00	1,060,075.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	235,268,202.53	1,232,036,899.42
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	210,865.01	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	210,865.01	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(210,865.01)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	235,057,337.52	1,232,036,899.42

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	152,806,215.00	1,103,354,530.46	1,503,672,377.05	2,759,833,122.51
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	152,806,215.00	1,103,354,530.46	1,503,672,377.05	2,759,833,122.51
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	152,806,215.00	1,103,354,530.46	1,503,672,377.05	2,759,833,122.51
D08	Тайлант үеийн үр дүн			1,232,036,899.42	1,232,036,899.42
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	152,806,215.00	1,103,354,530.46	2,735,709,276.47	3,991,870,021.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл

1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	978399500.00	977339425.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	978399500.00	977339425.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	948615000.00	947554925.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	723641000.00	722580925.00
210101	Үндсэн цалин	645441100.00	644381025.00
210104	Урамшуулал	41897600.00	41897600.00
210105	Гэрээт ажлын хөлс	36302300.00	36302300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97232100.00	97232100.00
210201	Тэтгэврийн даатгал	68422500.00	68422500.00
210202	Тэтгэмжийн даатгал	7202300.00	7202300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5762000.00	5762000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1440500.00	1440500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14404800.00	14404800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38034000.00	38034000.00
210301	Гэрэл, цахилгаан	3074000.00	3074000.00
210302	Түлш, халаалт	34960000.00	34960000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8680100.00	8680100.00
210401	Бичиг хэрэг	309000.00	309000.00
210402	Тээвэр, шатахуун	1181300.00	1181300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1227800.00	1227800.00
210404	Ном, хэвлэл	441400.00	441400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5520600.00	5520600.00
2105	Нормативт зардал	62992100.00	62992100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	429700.00	429700.00
210502	Хоол, хүнс	56835400.00	56835400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5727000.00	5727000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	750000.00	750000.00
210604	Урсгал засвар	750000.00	750000.00
2107	Томилолт, зочны зардал	353200.00	353200.00
210702	Дотоод албан томилолт	353200.00	353200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3136100.00	3136100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2636100.00	2636100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500000.00	500000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13796400.00	13796400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13796400.00	13796400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29784500.00	29784500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	29784500.00	29784500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29784500.0	29784500.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	978399500.00	977339425.00

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	939615500.00	938555425.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	939615500.00	938555425.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	38784000.00	38784000.00
132001	Орон нутгийн төсвөөс	38784000.00	38784000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	78.00	78.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	38.00	38.00
620003	Үйлчлэх ажилтан	30.00	30.00
620004	Гэрээт ажилтан	9.00	9.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	414.00	414.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	414.00	414.00
630001	Төрийн өмчит ЕБС	414.00	414.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	78.0	78.0
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	78.00	78.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8662933.00	8662933.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8662933.00	8662933.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8662933.00	8662933.00
2104	Хангамж, бараа материалын зардал	192933.00	192933.00
210401	Бичиг хэрэг	192933.00	192933.00
2105	Нормативт зардал	470000.00	470000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	470000.00	470000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8000000.00	8000000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8000000.00	8000000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8662933.00	8662933.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8662933.00	8662933.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8662933.00	8662933.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар хэрэгжүүлсэн.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь “Суралцагчдын хэрэгцээнд суурилсан хүртээмжтэй, сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан зөв хандлага төлөвшилттэй, бүтээлч, бие даан сурах хүсэл тэмүүлэлтэй хүүхдүүдийг бэлтгэхэд оршино”.

Тус сургууль нь 2021 оны хичээлийн жилд зорилготой ажиллаж, дараах үндсэн 5 дэд зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус албанаас сургуулийн 2020 оны үйл ажиллагаанд баримтын шалгалт хийгдсэн.

Тус сургуулийн дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар дотоод аудитаас туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1055.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 15.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 11.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1222.9 сая төгрөгөөр буюу 43.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	11925.2		-11925.2
Урьдчилгаа			
Бараа материал	147219.1	115196.2	32022.9
Үндсэн хөрөнгө	2621044.1	3887888.3	1266844.2
Нийт хөрөнгө	2780188.4	4003084.5	1222896.0
Өр төлбөр	20355.3	11214.5	-9140.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2759833.1	3991870.0	1232036.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2780188.4	4003084.5	1222896.0

Авлага дансны үлдэгдэл оны эхнээс 11.9 сая төгрөгөөр буурч үлдэгдэлгүй гарсан нь оны эхний нийгмийн даатгалын шимтгэл, татварын авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 115.2 сая төгрөг болж 32.0 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 125.8 сая төгрөгийн материал худалдан авч, 138.9 сая төгрөгийн материал зарцуулж, 20.5 сая төгрөгийн материалыг данснаас хассан байна. Аж ахуйн материал дансны үлдэгдэл нэмэгдэж, бусад материалын үлдэгдэл оны эхнээс буурсан байна.

Данснаас хассан материал нь урьд жилүүдэд хоолны зардлын төсвөөс авсан гэх материалыг хүнсний материалд бүртгэж ирснээс 17.4 сая төгрөгийг үндсэн хөрөнгөнд

шилжүүлэн, 3.1 сая төгрөгийн материалыг данснаас хасжээ. Ингэхдээ дээрх тооцоо үнэн зөв эсэхийг сумын санхүүгийн албаар хянуулж баталгаажуулаагүй, хөрөнгийг данснаас хасах талаар тушаал шийдвэр гаргаж албажуулан баримтжуулаагүй байна.

Өмнөх оны аудитаар хүнсний материалын тооллоготой холбоотой зөрчилтэй асуудал илрээгүй байгаагаас үзэхэд дээрх асуудлыг санаатай нуун дарагдуулсан байх магадлалтай байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1266.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 10.1 сая, хөрөнгийн санхүүжилтээр орлогод авсан 1356.1 сая, бараа материалаас шилжүүлсэн 17.4 сая төгрөгөөр нэмэгдэж, үдсэн хөрөнгөнд 117.2 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна. Дуусаагүй барилга данснаас барилга байгууламж дансанд 250.0 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1232.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 2350.6 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 1059.7 сая төгрөгөөр буюу 82.0 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй орлого, урсгал санхүүжилт байна.

Нийт зардал 1118.5 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 62.8 сая төгрөгөөр буюу 6.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан норматив зардал, бусад бараа үйлчилгээний зардал байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны анх батлагдсан төсөв 969.7 сая төгрөг, тодотгосон төсөв 977.3 сая төгрөг байна. Тодотгосон төсөв нь анх баталсан төсвөөс 7.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

Цалин, хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 134.0 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1.5 сая төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллыг 3.0 сая төгрөгөөр, хоолны зардал 43.0 сая төгрөгөөр хасаж тодотгосон байна.

Энэ нь анх баталсан төсөвт цалингийн зардлыг 134.0 сая төгрөгөөр дутуу суулгасан, нэмэгдэл, урамшлын зардлыг төсөвт суулгаагүй байсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь тайлант онд 978.4 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 977.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 977.3 сая төгрөг буюу 99.9 хувьтай байна.

Нийт төсвийн 73.9 хувийг цалин, 9.9 хувийг НДШ-ийн зардал, 3.9 хувийг тогтмол зардал, 0.7 хувийг хангамж бараа материалын зардал, 6.4 хувийг норматив зардал, 1.4 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 3.0 хувийг төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 8.6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна. Үүнээс хангамж бараа материалын зардалд 0.2 сая, норматив зардал 0.5 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 8.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай цалин, НДШ-ийн зардал, тогтмол зардал, хоолны зардал, үдийн цайны зардалд нийтдээ 968.0 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлээс үйл ажиллагаатай холбоотой Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад тэвчиж болох бусад урсгал зардал 32.5 сая төгрөгийн 10 хувь буюу 3.2 сая төгрөгөөр төсвийг хэмнэж ажиллаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэхүйц асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

Хүнсний бараа материал дансанд урьд жилүүдэд хоолны зардлын төсвөөс авсан гэх материалыг бүртгэж ирснээс 17.4 сая төгрөгийг үндсэн хөрөнгөнд шилжүүлэн, 3.1 сая төгрөгийн материалыг данснаас хасжээ. Ингэхдээ дээрх тооцоо үнэн зөв эсэхийг сургуулийн удирдлага, санхүүгээс хянаж баталгаажуулаагүй, сумын санхүүгийн албаар хянуулаагүй, сумын удирдлагад танилцуулаагүй баримтжуулалт хангалтгүй байна.

Өмнөх оны аудитаар хүнсний материалын тооллоготой холбоотой зөрчилтэй асуудал илрээгүй байгаагаас үзэхэд дээрх асуудлыг санаатай нуун дарагдуулсан байх магадлалтай байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь 2021 онд нийт 1,016.6 сая төгрөгийн 24 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 16 мэдээллийг хугацаандаа байршуулж, 8 мэдээллийг мэдээлээгүй, 2 мэдээлэл буюу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт байршуулах хугацаа болоогүй байна. Шилэн дансны мэдээллийг мэдээлсэн байдлын хувь 66.7 хувьтай байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд бүртгэл тайлагнал, шилэн данстай холбоотой 19.3 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж, төсвөөс зарцуулагдаагүй 11.9 сая төгрөгийн төсөвт буцаан төвлөрүүлэхгүйгээр татварын тооцоонд шилжүүлж авлага үүсгэсэн зөрчилд албан шаардлага өгөгдсөн байна. Давтан шалгаж үзэхэд авлагыг барагдуулсан ба зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийтдээ 42.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 17.4 сая төгрөгийн залруулга хийгдэж, 1.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 20.5 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөгдлөө.

4.1 Залруулсан алдаа

4.1 Залруулсан алдаа

Бараа материал данснаас үндсэн хөрөнгөд шилжүүлсэн 17.4 сая төгрөгийн залруулах бичилт хийхдээ үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэж тайлант үеийн орлогыг нэмэгдүүлснийг зардал бууруулж залруулга хийлээ.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 1.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Дотуур байрны хүүхдүүдийн хоолонд өдөр бүрийн хоолны талоны дүнгээр нийт 17295 хүүхдэд 61,461.2 мянган төгрөгийн хүнсний материал зарцуулсан бөгөөд Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор батлагдсан хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын нормоор тооцож үзэхэд жилийн дүнгээр батлагдсан нормыг 1,361.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн төсвөөс илүү зарлага гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор батлагдсан хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын нормт хэмжээг хэтрүүлэн зарцуулсан 1,361.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлж, аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан дахь төсвийн орлогын 100020051005 тоот дансанд оруулах төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар 20.5 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Хүнсний бараа материал дансанд урьд жилүүдэд хоолны зардлын төсвөөс авсан гэх материалыг бүртгэж ирснээс 17.4 сая төгрөгийг үндсэн хөрөнгөнд шилжүүлэн, 3.1 сая төгрөгийн материалыг данснаас хасжээ. Ингэхдээ дээрх тооцоо үнэн зөв эсэхийг сумын санхүүгийн албаар хянуулж баталгаажуулаагүй, хөрөнгийг данснаас хасах талаар тушаал шийдвэр гаргаж албажуулан баримтжуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүнсний материалын данснаас хассан 20.5 сая төгрөгийн материалын тооцоог өмнөх онуудын санхүүгийн анхан шатны баримтуудад үндэслэн дахин хийж, сумын санхүүгийн албаар хянуулан баталгаажуулж илэрсэн зөрчлийг бүрэн арилгаж албан шаардлагын биелэлтийг 2021 оны 05 дугаар сарын 01-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх талаар албан шаардлага өгөв.

2. Шилэн дансны тайлант оны 3 дугаар улирлын төсвийн гүйцэтгэлийг хугацаа хоцроож оруулсан, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 3.8 сая төгрөгийн орлогын 1 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 398.9 сая төгрөгийн 5 мэдээлэл, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг тус тус оруулаагүй, 11.2 сая төгрөгийн авлага үүсгэсэн тухай шийдвэрийг байршуулаагүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 66.7 хувьтай байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 10 дугаар сарын 01-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх талаар албан шаардлага өгөв.

3. Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад тэвчиж болох бусад урсгал зардал 32.5 сая төгрөгийн 10 хувь буюу 3.2 сая төгрөгөөр төсвийг хэмнэж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 10 дугаар сарын 01-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль	4	42.5	2	17.4	1	1.4	3	23.7		